



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 280 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2024 оны төсвийн орлогын сар, улирлын хуваарь"-ийг 1 дүгээр хавсралтаар, мөн тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2024 оны төсвийн орлого төвлөрүүлэгч байгууллагын сар, улирлын хуваарь"-ийг 2 дугаар хавсралтаар, мөн тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2024 оны төсвийн зарлага, санхүүжилтийн сар, улирлын хуваарь"-ийг 3 дугаар хавсралтаар, мөн тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2024 оны төсвийн хөтөлбөр, арга хэмжээний сар, улирлын хуваарь"-ийг 4 дүгээр хавсралтаар, мөн тушаалын 8 дугаар хавсралтаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн сар, улирлын хуваарь"-ийг 5 дугаар хавсралтаар, мөн тушаалын 9 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн сар, улирлын хуваарь"-ийг 6 дугаар хавсралтаар, мөн тушаалын 10 дугаар хавсралтаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээл, тусламжаас 2024 онд санхүүжих төсөл, арга хэмжээний сар, улирлын хуваарь"-ийг 7 дугаар хавсралтаар, мөн тушаалын 11 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2024 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн сар, улирлын хуваарь"-ийг 8 дугаар хавсралтаар, мөн тушаалын 12 дугаар хавсралтаар батлагдсан "Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн сар, улирлын хуваарь"-ийг 9 дүгээр хавсралтаар, мөн тушаалын 13 дугаар хавсралтаар батлагдсан "Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн сар, улирлын хуваарь"-ийг 10 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Санхүүжилтийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу олгохыг Төрийн сангийн газар /Б.Цогбадрах/-т зөвшөөрсүгэй.

Б.ЖАВХЛАН

9763000391